



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2016 оны 12 сарын 08 өдөр

Дугаар

Н/416

Улаанбаатар хот

Аргачлал батлах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолын 2 дахь заалт, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2016 оны А/349 дугаар тушаалаар батлагдсан “Улсын бүртгэлийн ерөнхий газрын хөдөлмөрийн дотоод журам”-ын 6.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү аргачлалыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Ерөнхий газрын газар, нийслэлийн Улсын бүртгэлийн газар, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, дүүргийн бүртгэлийн хэлтсийн дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Т.Гантөмөр/-т даалгасугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2014 оны 1477, 2015 оны 1748 дугаар тушаалуудыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ

**ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

**1.1. Зорилго**

1.1.1. Оюуны өмч, Улсын бүртгэлийн байгууллагын зорилго, зорилт, бодлогын болон удирдлагын баримт бичгийн хэрэгжилт, үйл ажиллагааны явцад хяналт-шинжилгээ хийж үнэлэх, үр дүнг тооцох ажлыг зохион байгуулахад оршино.

**1.2. Зарчим**

1.2.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаанд дараах зарчмыг мөрдөн ажиллана. Үүнд:

- 1.2.1.1. Хууль дээдлэх, шударга ёсыг хангах, хөндлөнгийн нөлөөнөөс хараат бус, талуудын оролцоог хангасан байх;
- 1.2.1.2. Үйл ажиллагаа, үнэлгээ, тайлан ил тод, нээлттэй, бодитой, үнэн зөв байх;
- 1.2.1.3. Судалгаа тооцоонд үндэслэсэн, үр дүнд чиглэсэн байх;
- 1.2.1.4. Хяналт-шинжилгээ тасралтгүй, үнэлгээг тогтмол хийдэг байх;
- 1.2.1.5. Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд саад учруулахгүй, шуурхай байх;
- 1.2.1.6. Хяналт-шинжилгээний зорилго, суурь болон шалгуур үзүүлэлт, хэмжүүр тодорхой байх.

**1.3. Арга зүй**

1.3.1. Хууль зүйн сайдын 2014 оны А/01 дүгээр тушаалаар батлагдсан "Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал" болон энэ аргачлалын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

1.3.2. Хяналт-шинжилгээ хийхдээ баримт бичиг судлах, холбогдох албан хаагчидтай ярилцах, санал асуулга явуулах, ажлын бодит гүйцэтгэлийг газар дээр нь шалгах зэрэг дүн шинжилгээний түгээмэл аргуудыг хэрэглэнэ.

**1.4. Хамрах хүрээ**

1.4.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээнд Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газар, ерөнхий газрын газар, нийслэлийн Улсын бүртгэлийн газар, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, дүүргийн бүртгэлийн хэлтэс хамрагдана.

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх**

**2.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх хугацаа, төлөвлөлт**

2.1.1. Ерөнхий газар, ерөнхий газрын газар, нийслэлийн Улсын бүртгэлийн газар, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, дүүргийн бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан нэгж хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

2.1.2. Ерөнхий газрын газар, нийслэлийн Улсын бүртгэлийн газар, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, дүүргийн бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаа, тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хагас, бүтэн жил тутам, тухайн улирлын сүүлийн

сарын 20-ны өдрөөс дараа сарын 10-ны өдрийн дотор хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг энэхүү аргачлалын 1, 2, 5 дугаар хавсралтад заасан шалгуур үзүүлэлтийн дагуу гаргаж, зөвлөмж дүгнэлтийг танилцуулна.

2.1.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан нэгж нь Ерөнхий газрын газар, хэлтэс, салбар, нэгж бүрт Ерөнхий газрын даргын шийдвэр /төлөвлөгөө, удирдамж/-ээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

2.1.4. Хууль зүйн сайдын 2014 оны А/01 дүгээр тушаалаар батлагдсан "Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал"-ын 4.1-д заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөг баталж, жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлнэ.

2.1.5. Тамгын газраас холбогдох эрх зүйн актын биелэлтийг 6 дугаар сарын 25, 12 дугаар сарын 30, Тогтвортой хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын биелэлтийг 12 дугаар сарын 15, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг 6 дугаар сарын 10, 12 дугаар сарын 15, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг 6 дугаар сарын 25, 12 дугаар сарын 30, Үндэсний хөтөлбөрийн биелэлтийг 1 дүгээр сарын 15, Улсын төсөв, гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төслийн хэрэгжилтийг 1 дүгээр сарын 15-ны өдөр Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан нэгжид ирүүлнэ.

2.1.6. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан нэгж нь бодлогын баримт бичиг, хууль, холбогдох эрх зүйн актын хэрэгжилтийн үр нөлөөнд Хууль зүйн яамны төрийн нарийн бичгийн даргын 2011 оны 54 тоот тушаалаар баталсан "Хуулийн хэрэгжилтийн үр нөлөөнд үнэлгээ хийх аргачлал"-ыг баримтлан үнэлгээ хийж, Засгийн газрын 322 тоот тогтоолын 1-1 хавсралтаар батлагдсан хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлнэ.

## **2.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээнд тавигдах шаардлага**

Хяналт-шинжилгээ, үнэлгээнд дараах шаардлага тавигдана. Үүнд:

2.2.1. Төлөвлөгөө, удирдамж, үйл явц, тайлан нь холбогдох эрх зүйн актад нийцсэн байх;

2.2.2. Бүрэлдэхүүн нь багаар ажиллах бөгөөд мэргэшсэн, туршлагатай байх, шаардлагатай бол гадны судлаач, мэргэжилтнүүдийг оролцуулах;

2.2.3. Тайлант хугацааг бүрэн хамруулсан, урьд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг харгалзаж үзэх;

2.2.4. Удирдамжид заагдсан үйл ажиллагааны гүйцэтгэлийг бүрэн хангасан байх;

2.2.5. Баримт, материал нь нотлогдохуйц, баримтжуулалт сайтай байх;

2.2.6. Заавар, зөвлөмж өгч, үйл ажиллагаанд нь тусалсан байх.

## **2.3. Системчилсэн үнэлгээ хийх**

2.3.1. Ерөнхий газрын газар, нийслэлийн Улсын бүртгэлийн газар, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, дүүргийн бүртгэлийн хэлстийн үйл ажиллагаанд Ерөнхий газрын даргын баталсан удирдамжаар системчилсэн үнэлгээ хийнэ.

2.3.2. Системчилсэн үнэлгээ хийхэд Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2011 оны 55 дугаар тушаалаар батлагдсан "Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлал"-ыг баримтална.

## **2.4. Хэрэглэгчийн үнэлгээ хийх**

2.4.1. Ерөнхий газрын газар, нийслэлийн Улсын бүртгэлийн газар, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, дүүргийн бүртгэлийн хэлстээс үзүүлдэг үйлчилгээний талаар жилд нэг удаа судалгааны байгууллагаар хэрэглэгчийн үнэлгээ хийлгэнэ.

2.4.2. Хэрэглэгчийн үнэлгээг агентлаг, байгууллагын бодлогын иргэдэд үзүүлсэн үр нөлөө, үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар тухайн байгууллагын үйлчлүүлэгч насанд хүрсэн иргэдийн 3-5 хүртэлх хувийг, эсхүл тухайн байгууллагаар үйлчлүүлэгч аж ахуйн нэгжийг хамруулан явуулсан санал асуулгын дүнг үндэслэн гаргана.

2.4.3. Хэрэглэгчийн үнэлгээ хийлгэхтэй холбогдон гарах зардлыг байгууллагын тухайн жилийн төсөвт тусгасан байна.

## **2.5. Эрсдлийн үнэлгээ хийх**

2.5.1. Ерөнхий газрын үйл ажиллагаанд Хууль зүйн сайдын 2013 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан "Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын эрсдлийн үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу жил бүр эрсдлийн үнэлгээ хийнэ.

2.5.2. Тухайн жилд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээ нь эрсдлийн үнэлгээнд суурилсан байна.

## **2.6. Өөрийн үнэлгээ хийх**

2.6.1. "Өөрийн үнэлгээ" гэж тухайн нэгж өөрийн үйл ажиллагаа, бодлогын хэрэгжилтэд өөрөө үнэлгээ өгөх үйл ажиллагааг хэлнэ.

2.6.2. Ерөнхий газрын газар, нийслэлийн Улсын бүртгэлийн газар, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, дүүргийн бүртгэлийн хэлтэс нь өөрийн үнэлгээг бодитой гаргах үүрэгтэй бөгөөд, үнэлгээ өгөх үндэслэл болсон тоо баримтыг үйл ажиллагааны тайланд тусгаж, холбогдох нотлох баримтыг хавсарган үйл ажиллагаанд өгөх өөрийн үнэлгээг 6, 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан нэгжид ирүүлнэ.

## **Гурав.Тайлан бичих, танилцуулах**

### **3.1. Тайлан бичих аргачлал**

3.1.1. Ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан нэгж хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан бичнэ.

3.1.2. Ерөнхий газрын газар, нийслэлийн Улсын бүртгэлийн газар, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, дүүргийн бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан нь дараах баримтаас бүрдэнэ. Үүнд:

3.1.2.1.Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан;

3.1.2.2.Нэгжийн үйл ажиллагааны үр дүнгийн ерөнхий үнэлгээ;

3.1.2.3.Хэрэглэгчийн үнэлгээ /тухайн нэгжид хийгдсэн тохиолдолд/;

3.1.2.4.Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлт.

3.1.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд тогтоогдсон нөхцөл байдал, холбогдох тоо баримт, санал, дүгнэлт, зөвлөмжийг тусгасан байхаас гадна шаардлагатай тохиолдолд хүснэгт, график, зураг, дүрс бичлэг зэргийг хавсаргаж болно.

3.1.4. Хяналт шинжилгээ, үнэлгээний тайланг дээд газарт тайлагнах үндсэн хугацаанаас ажлын 5-с доошгүй өдрийн өмнө Ерөнхий газрын даргад урьдчилан танилцуулсан байна.

### **Дөрөв. Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих**

4.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг хэрэгжүүлэх зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн яамнаас тухайн жилийн гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх чиглэл ирүүлснээс хойш ажлын 5 өдрийн дотор Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар төлөвлөгөө баталж, нэн даруй яаманд болон дотоод нэгжүүдэд хүргүүлнэ.

4.2. Ерөнхий газрын гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө батлагдсан, тухайн нэгж дээр хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан нэгжийн даргад танилцуулагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор энэхүү аргачлалын 3 дугаар хавсралтаар батлагдсан загварын дагуу бүх нэгж өөрсдийн гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөг боловсруулж, Ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан нэгжид ирүүлнэ.

4.3. Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилтэд Ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан нэгж хяналт тавина.

4.4. Ерөнхий газар, Ерөнхий газрын газар, нийслэлийн Улсын бүртгэлийн газар, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, дүүргийн бүртгэлийн хэлтэс нь гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилийн сүүлийн сарын 20-ны өдрийн дотор гаргаж, Ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан нэгжид ирүүлнэ.

## **Тав.Үр дүнг тооцох, мэдээллэх, урамшуулах**

### **5.1. Үр дүнг тооцох**

5.1.1. Ерөнхий газрын газар, нийслэлийн Улсын бүртгэлийн газар, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, дүүргийн бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагааны үр дүнгийн ерөнхий үнэлгээг хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан нэгжийн өгсөн үнэлгээгээр тооцно.

5.1.2. Хэрэглэгчийн үнэлгээг хөндлөнгийн байгууллагын тайланд өгсөн үнэлгээгээр тооцно.

5.1.3. Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга, аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Ерөнхий газрын даргатай тухайн онд байгуулсан гэрээний биелэлтийг Ерөнхий газрын даргаас гэрээг дүгнэсэн хувиар тодорхойлно.

5.1.4. Ерөнхий газрын газар, нийслэлийн Улсын бүртгэлийн хэлтэс, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, дүүргийн бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагааны үр дүнгийн хэсэг тус бүрийн дундаж оноо нь үзүүлэлт бүрийн хэрэгжилтийн түвшин (хувь)-ий нийлбэрийг нийт үзүүлэлтийн тоонд хувааж гаргасан дундаж хувиар, ерөнхий оноо нь үзүүлэлт бүрийн хэрэгжилтийн түвшин (хувь)-ий нийлбэрээр илэрхийлэгдэнэ.

5.1.5 Зарим шалгуур үзүүлэлт нь тухайн нэгжид хамаарахгүй эсхүл тухайн жилд хийгдээгүй тохиолдолд нийт үзүүлэлтийн тооноос хасч тооцно.

5.1.6. Бодлогын зорилтын хэрэгжилтийн түвшинг тодорхойлохдоо тавьсан зорилтын гүйцэтгэл тогтоох шалгуур үзүүлэлтийн үр дүнг (Г) хүрэх түвшин буюу тавьсан зорилтод (З) харьцуулж хувиар илэрхийлнэ (Г/Зх100).

5.1.7. Тоогоор илэрхийлж үнэлэх боломжгүй зорилтын шалгуур үзүүлэлтийн биелэлтийн хувийг тодорхойлоход дараах зарчмыг баримтална:

5.1.7.1. Тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, энэ талаар холбогдох шийдвэр гарч, үр дүн гарсан бол 100 хувь;

5.1.7.2. Тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч санхүү, зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа бол 90.0 хувь (80.0-100.0 хүртэл хувь);

5.1.7.3. Тавьсан зорилтод хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол гүйцэтгэлийн байдлыг харгалзан 70.0 хувь (60.0-80.0 хүртэл хувь);

5.1.7.4. Тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол хийгдэж байгаа ажлын түвшинг харгалзан 50.0 хувь (40.0-60.0 хүртэл хувь);

5.1.7.5. Тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа бол хийгдэж байгаа ажлын түвшинг харгалзан 30.0 хувь (20.0-40.0 хүртэл хувь);

5.1.7.6. Тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон арга хэмжээг авч эхэлж байгаа бол ажлын түвшинг харгалзан 10.0 хувь (0-20.0 хүртэл хувь);

5.1.7.7. Тухайн зорилтыг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол биелэлтийн хувийг "0" гэж үзнэ.

### **5.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг мэдээллэх**

5.2.1. Үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Ерөнхий газрын газар, нийслэлийн Улсын бүртгэлийн газар, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, дүүргийн

бүртгэлийн хэлтэст “Үр дүнг үнэлж, холбогдох арга хэмжээ авах тухай” Ерөнхий газрын даргын шийдвэр гарсны дараа хүргүүлнэ.

5.2.2. Бусад чиглэлээр хийгдсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг тухайн жилийн төлөвлөгөө, удирдамжид заасан хугацаанд холбогдох нэгжүүдэд хүргүүлнэ.

### 5.3. Урамшуулал

5.3.1. Ерөнхий газрын газар, Нийслэлийн улсын бүртгэлийн газар, Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, дүүргийн бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагааны үр дүнг үнэлж, дор дурдсан үнэлгээний аль нэгийг өгнө. Үүнд:

- 90-100 оноо авсан бол “А” буюу “Маш сайн”;
- 80-89 оноо авсан бол “В” буюу “Сайн”;
- 70-79 оноо авсан бол “С” буюу “Хангалттай”;
- 60-69 оноо авсан бол “D” буюу “Дутагдалтай”;
- 0-59 оноо авсан бол “F” буюу “Хангалтгүй”.

5.3.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ерөнхий үнэлгээгээр хамгийн өндөр оноо авсан Ерөнхий газрын газар, нийслэлийн Улсын бүртгэлийн газрыг I, II байр, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, дүүргийн бүртгэлийн хэлтсийг I, II, III байр тус тус эзлүүлж, дараах мөнгөн шагналаар шагнаж урамшуулна. Үүнд:

Ерөнхий газрын газар, нийслэлийн Улсын бүртгэлийн газрыг:

- 1 дүгээр байр 1.500.000 төгрөг хүртэл;
- 2 дугаар байр 1.000.000 төгрөг хүртэл;
- 3 дугаар байр 500.000 төгрөг хүртэл.

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, дүүргийн бүртгэлийн хэлтсийг:

- 1 дүгээр байр 1.500.000 төгрөг хүртэл;
- 2 дугаар байр 1.000.000 төгрөг хүртэл;
- 3 дугаар байр 500.000 төгрөг хүртэл.

5.3.3. Ерөнхий газрын газар, нийслэлийн Улсын бүртгэлийн газар, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, дүүргийн бүртгэлийн хэлтсээс ерөнхий үнэлгээгээр хамгийн өндөр оноо авсан нэг нэгжийн даргыг нэг сарын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн шагналаар урамшуулна.

5.3.4. Урамшуулалд зарцуулах хөрөнгийг Ерөнхий газрын төсөвт жил бүр тусгана.

5.3.5. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр байр эзэлж, бусдыгаа манлайлан ажилласан Ерөнхий газрын газар, нийслэлийн Улсын бүртгэлийн газар, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, дүүргийн бүртгэлийн хэлтсийн хамт олны зургийг байгууллагын хүндэт самбар, цахим хуудаст байрлуулж, тухайн нэгжийн үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээллийг мэдээлнэ.

5.3.6. Тухайн жилд “А” буюу “Маш сайн” үнэлгээ авсан аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, дүүргийн бүртгэлийн хэлтсийг түшиглэн бүсийн сургалт, семинарыг зохион байгуулж болно.

--- оОо ---

ЕРӨНХИЙ ГАЗРЫН ГАЗАР, НИЙСЛЭЛИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗРЫН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭНИЙ  
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

| Газрын нэр                                       |                                                                                                                                                                                | .....газар                     |                                                                     |
|--------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------|---------------------------------------------------------------------|
| Шалгуур үзүүлэлт                                 |                                                                                                                                                                                | Үр дүнгийн үнэлгээ             |                                                                     |
|                                                  |                                                                                                                                                                                | Өөрийн үнэлгээ<br>/0-100 хувь/ | ХШУДА-ын<br>асуудал<br>хариуцсан<br>нэгжийн үнэлгээ<br>/0-100 хувь/ |
| 1.Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр нөлөө        | 1.1.Тогтвортой хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт                                                                                           |                                |                                                                     |
|                                                  | 1.2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт                                                                                                                       |                                |                                                                     |
|                                                  | 1.3.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн хэрэгжилт                                                                                                    |                                |                                                                     |
|                                                  | 1.4.УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт                                                     |                                |                                                                     |
|                                                  | 1.5.УИХ, Засгийн газраас баталсан Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт                                                                                                               |                                |                                                                     |
|                                                  | 1.6.Улсын болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн хэрэгжилт                                                                                     |                                |                                                                     |
|                                                  | ✓ 1.7.Ерөнхий газрын даргаас өгөгдсөн үүрэг, даалгавар, тушаал, ДЗХ-ын шийдвэрийн хэрэгжилт /дүрэм, журам, бусад/                                                              |                                |                                                                     |
| 2.Нэгжийн үйл ажиллагааны үзүүлэлтийн үнэлгээ    | ✓ 2.1.Нэгжийн даргын үр дүнгийн гэрээний биелэлт                                                                                                                               |                                |                                                                     |
|                                                  | ✓ 2.2.Тухай газрын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт                                                                                                              |                                |                                                                     |
|                                                  | ✓ 2.3.Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлт                                                                                                                               |                                |                                                                     |
|                                                  | ✓ 2.4.ОӨУБЕГ-аас хэрэгжүүлж буй тодорхой арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ/ Гэмт хэрэг, Авлига, Терроризмаас урьдчилан сэргийлэх, Жендер, Хүний эрхийг хангах/ |                                |                                                                     |
|                                                  | ✓ 2.5.Санхүүгийн үйл ажиллагааны талаарх үнэлгээ /НУБГ-т хамаарах/                                                                                                             |                                |                                                                     |
| 3.Нэгжийн үндсэн чиг үүргийн үнэлгээ             | ✓ 3.1.Нэгжийн үндсэн чиг үүргийн хэрэгжилтийн үнэлгээ                                                                                                                          |                                |                                                                     |
| 4.Нэгжийн нээлттэй байдлын үнэлгээ               | ✓ 4.1.Нэгжийн нээлттэй, ил тод байдлын үнэлгээ                                                                                                                                 |                                |                                                                     |
| Ерөнхий оноо /Нийт онооны дээд хэмжээ 100 байна/ |                                                                                                                                                                                |                                |                                                                     |
| ҮНЭЛГЭЭ                                          |                                                                                                                                                                                |                                |                                                                     |
| ЭЗЭЛСЭН БАЙР                                     |                                                                                                                                                                                |                                |                                                                     |

АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС, ДҮҮРГИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН  
ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

| Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс,<br>дүүргийн бүртгэлийн хэлтсийн нэр |                                                                                                                                                                              | .....аймгийн УБХ<br>.....дүүргийн БХ |                                                                     |
|----------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------|---------------------------------------------------------------------|
| Шалгуур үзүүлэлт                                                     |                                                                                                                                                                              | Үр дүнгийн үнэлгээ                   |                                                                     |
|                                                                      |                                                                                                                                                                              | Өөрийн үнэлгээ<br>/0-100 хувь/       | ХШУДА-ын<br>асуудал<br>хариуцсан<br>нэгжийн үнэлгээ<br>/0-100 хувь/ |
| 1.Нэгжийн<br>үйл<br>ажиллагааны<br>үзүүлэлтийн<br>үнэлгээ            | 1.1.Нэгжийн даргын үр дүнгийн гэрээний биелэлт                                                                                                                               |                                      |                                                                     |
|                                                                      | 1.2.Тухай хэлтсийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт                                                                                                            |                                      |                                                                     |
|                                                                      | 1.3.Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлт                                                                                                                               |                                      |                                                                     |
|                                                                      | 1.4.ОӨУБЕГ-аас хэрэгжүүлж буй тодорхой арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ/ Гэмт хэрэг, Авлига, Терроризмаас урьдчилан сэргийлэх, Жендер, Хүний эрхийг хангах/ |                                      |                                                                     |
|                                                                      | 1.5. Ерөнхий газрын даргаас өгөгдсөн үүрэг, даалгавар, тушаал, ДЗХ-ын шийдвэрийн хэрэгжилт /дүрэм, журам, бусад/                                                             |                                      |                                                                     |
| 2.Нэгжийн<br>үндсэн чиг<br>үүргийн<br>үнэлгээ                        | 2.1.Иргэний бүртгэл хөтлөх үйл ажиллагаа                                                                                                                                     |                                      |                                                                     |
|                                                                      | 2.2.Эд хөрөнгийн эрхийн бүртгэл хөтлөх үйл ажиллагаа                                                                                                                         |                                      |                                                                     |
|                                                                      | 2.3.Хуулийн этгээдийн бүртгэл ийн үйл ажиллагаа                                                                                                                              |                                      |                                                                     |
|                                                                      | 2.4.Дотооддоо бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавьсан байдал                                                                                                               |                                      |                                                                     |
|                                                                      | 2.5.Архивын баримт бичиг хадгалалт байдал                                                                                                                                    |                                      |                                                                     |
| 3.Санхүүгийн<br>үйл<br>ажиллагааны<br>талаарх<br>үнэлгээ             | 3.1.Санхүүгийн үйл ажиллагааны талаарх үнэлгээ                                                                                                                               |                                      |                                                                     |
| 4.Нэгжийн<br>нээлттэй<br>байдлын<br>үнэлгээ                          | 4.1.Нэгжийн нээлттэй, ил тод байдлын үнэлгээ                                                                                                                                 |                                      |                                                                     |
| Ерөнхий оноо /Нийт онооны дээд хэмжээ 100 байна/                     |                                                                                                                                                                              |                                      |                                                                     |
| ҮНЭЛГЭЭ                                                              |                                                                                                                                                                              |                                      |                                                                     |
| ЭЗЭЛСЭН БАЙР                                                         |                                                                                                                                                                              |                                      |                                                                     |

--- оОо ---

БАТЛАВ.

..... /газар, хэлтэс/-ийн дарга  
..... /

**... /ГАЗАР, ХЭЛТЭС/-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ... ОНД ХИЙСЭН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ САЙЖРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

| д/д           | Арга хэмжээ | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт                               |         | Хариуцах<br>нэгж<br>/албан<br>хаагч/ | Биелэлт |
|---------------|-------------|-------------------------------------------------------------|---------|--------------------------------------|---------|
|               |             | Арга хэмжээ /гарц/-ний<br>шалгуур үзүүлэлт, хүрэх<br>түвшин | Хугацаа |                                      |         |
